Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 03/01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газар нь нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд төрийн бодлого шийдвэрийг хэрэгжүүлэн, нийтийн үйлчилгээг иргэдэд хуулийн хүрээнд шуурхай хариуцлагатай шударга хүргэж орон нутгаа хөгжүүлэх шууд ардчиллын зарчмыг баримталсан шийдвэрүүдийг гарган хэрэгжилтийг хангуулах эрхэм зорилго үйл ажиллагааны чиглэл зорилгоо тодорхойлон ажилласан, Төв аймгийн төрийн сангийн хэлтэст санхүүгийн тайлангаа нэгтгүүлдэг, Төв аймгийн ТЕЗ-ийн харьяа байгууллага юм.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төр, засгийн бодлого шийдвэрийг анхан шатанд мөрдөж, хэрэгжүүлэх
- Сум, орон нутгаа хөгжүүлэх шууд ардчиллын зарчмыг баримталсан шийдвэрүүдийг гарган хэрэгжилтийг хангуулах
- Хүртээмжтэй, чанартай төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газрын дотоод аудитын чиг үүрэг, түүний үйл ажиллагааг аймгийн Санхүү хяналт, аудитын алба гүйцэтгэдэг. 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгдээгүй талаар ойлголт олж авснаар дотоод аудитын ажлыг аудитад ашиглахгүй гэж шийдвэрлэсэн.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 783,396.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 11,750.9 мянган төгрөгөөр тогтоож, ерөнхий материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 8,813.2 мянган төгрөгөөр тогтоосон.

Төлөвлөх үе шатанд тооцсон ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай үзсэн. Энэ нь төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын үзүүлэлтийг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцсон тул дахин тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг байдлын суурь үзүүлэлт, материаллаг байдлын түвшин, гүйцэтгэлийн материаллаг байдлын хувийг өөрчлөхгүйгээр 2021 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардал 697,263.9 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,458.9 мянган төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоосон материаллаг байдлын 75 хувиар буюу 7,844.2 мянган төгрөгөөр тогтоосон. Дахин шинэчлэн тооцсон материаллаг байдлын түвшин нь төлөвлөлтийн үе шатнаас 969.0 мянган төгрөгөөр буурсан байна.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны санхүүгийн байдал, үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Санхүүгийн “Acolous” программыг ашиглаж нягтлан бодох бүртгэлийг хөтөлж байна.

#### **Орлого:**

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 480,863.1 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 182,782.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд бусад орлого 70,533.9 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны орлогыг 734,343.5 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд орон нутгийн төсвөөс урсгал үйл ажиллагааны санхүүжилт 480,863.1 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд бусад орлого 70,533.9 мянган төгрөг, нийт үйл ажиллагааны мөнгөн орлогыг 551,397.0 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд иргэдээс хандив 6,210.0 мянган төгрөг, сургуулийн албан хаагчдын хандив 1,050.0 мянган төгрөг, Төв Чандмань ДЭХГ-аас Засгийн газраас төлсөн усны үнэ 7,501.5 мянган төгрөг, Сангийн яамнаас олгосон УБ-Дархан чиглэлийн зам "Борнуур" хөшөө нүүлгэн шилжүүлэх санхүүжилт 15,000.0 мянган төгрөг, статистикийн хэлтсээс өвс тэжээл урамшууллын зардалд 3,032,4 мянган төгрөг, хагас жилийн мал тооллогын зардалд 880.2 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс цэцэрлэгийн халаалтын зардалд 15,378.8 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-аас ковид, шүлхийний зардалд 5,000.0 мянган төгрөг, аймгийн Засаг даргын А/72 захирамжаар ковид цар тахлын хяналт шалгалтын зардалд 1,000.0 мянган төгрөг, А/128 захирамжаар биотехникийн зардалд 500.0 мянган төгрөг, Монгол тохь ХХК-с мод шилжүүлэн суулгахад 5,000.0 мянган төгрөг, хивэг тэжээлийн үнэнд 416.0 мянган төгрөг, УИХ-ын гишүүн Ж.Батжаргалаас хандив 1,000.0 мянган төгрөг, Гүн билэг Гоулд ХХК-с нийгмийн хариуцлагын гэрээгээр 5,000.0 мянган төгрөг, 1 ба 3 дугаар багийн Засаг дарга нараас өвсний үнэ 3,565.0 мянган төгрөг, нийт 70,533.9 мянган төгрөгийн орлого төвлөрсөн байна.

#### **Зардал:**

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газар нь 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлан дахь үйл ажиллагааны зардлын дүн 770,856.5 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлан дахь нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 487,271.0 мянган төгрөгөөр тайлагнасан байна.

**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Тус байгууллага төрийн сангийн 100140955001 тоот дансанд 480,863.1 мянган төгрөгийн орлого, 480,863.1 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Мөн нэмэлт санхүүжилтийн 100140955408 тоот дансанд 70,533.9 мянган төгрөгийн орлого, 70,533.9 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна.

**Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:**

Үндсэн хөрөнгө дансны эхний үлдэгдэл 5,514,677.3 мянган төгрөг, тайлант онд үнэ төлбөргүй хүлээж авсан орлогоор 113,300.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө шилжүүлэн авч, 4 байгууллагаас 16,407.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, бусад үндсэн хөрөнгө худалдан авсан байна.

Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 8,200.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгсэл, 21,524.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 4,708.4 мянган төгрөгийн тавилга эд хогшил, 4,896.9 мянган төгрөгийн бусад хөрөнгө, 1,375.0 мянган төгрөгийн программ хангамж, нийт 40,704.3 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор шийдвэрлэн акталж, үндсэн хөрөнгийн эцсийн үлдэгдэл 5,658,162.5 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны эхний үлдэгдэл 33,879.2 мянган төгрөг, тайлант онд худалдаж авсан 106,992.9 мянган төгрөг, ОБГ болон иргэд ААН-с үнэ төлбөргүй шилжүүлэн авсан тусгай зориулалтын материал 15,000.2 мянган төгрөг, шүүхийн шийдвэрээр хураагдсан 164.4 мянган төгрөгийн аж ахуйн материал, нийт 122,157.5 мянган төгрөгийн бараа материалыг орлогоор бүртгэж, тайлант онд 100,488.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулж, ЭМТ, ЕБС-д 16,159.2 мянган төгрөгийн бусад хангамжийн материалыг шилжүүлж, нийт 116,647.5 мянган төгрөгийн бараа материалыг зарлага болгож, бараа материалын эцсийн үлдэгдэл 39,389.2 мянган төгрөг байна.

**Авлага, өглөгийн талаар:**

Тайлант жилийн авлагын дансны эхний үлдэгдэл 39.3 мянган төгрөгийг бүрэн барагдуулж, эцсийн үлдэгдэлгүй болсон байна.

Өглөгийн данс эхний үлдэгдэл 1,477.1 мянган төгрөг, нэмэгдсэн 494,784.1 мянган төгрөг, хасагдсан 496,261.2 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 0 төгрөг байна.

Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч 19 байгууллагуудтай тооцооны дансдын үлдэгдлийг тооцоо нийлсэн баримтаар баталгаажуулсан байна.

**Санхүүгийн байдлын тайлангийн талаар:**

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн данс, арилжааны банкны харилцах данс үлдэгдэлгүй байна. Бараа материал 39,389.2 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 3,914,488.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	2,6	0	-2,6
Авлага	39.3	0	-39.3
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	33,879.2	39,389.2	5,510.0
Үндсэн хөрөнгө	3,957,946.7	3,914,488.5	-43,458.2
Нийт хөрөнгө	3,991,867.9	3,953,877.8	-37,990.1
Өр төлбөр	1,477.1	0	-1,477.1
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,990,390.8	3,953,877.8	-36,513.0
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,991,867.9	3,953,877.8	-37,990.1

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 0 төгрөг болж, өмнөх онд арилжааны банкин дахь нярвын нэр дээр байдаг байгууллагын эзэмшлийн картын дансны 2.6 мянган төгрөгийн үлдэгдлээр буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэлгүй болж, 39.3 мянган төгрөгийн авлагыг бүрэн барагдуулсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 39,389.2 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 5,510.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Бороо гоулд ХХК-с нийгмийн хариуцлагын гэрээгээр 4,500.0 мянган төгрөгийн хашааны төмөр хайс, явган хүний замын цементэн хавтан хандивласныг аж ахуйн материалд авсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 3,914,488.5 мянган төгрөг болж 43,458.2 мянган төгрөгөөр буурахад элэгдлээрээ өртгөө бүрэн нөхсөн, 317.6 мянган төгрөгийн дахин үнэлгээтэй 40,704.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг сумын ИТХ-ын 2021 оны 7 дугаар сарын 30-ны өдрийн 10 дугаар тогтоолоор шийдвэрлэж акталсан нь голлох нөлөөллийг үзүүлж байна.

Тайлант оны үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал 227,647.6 мянган төгрөг, данснаас хасагдсан хөрөнгийн элэгдэл 40,704.3 мянган төгрөг байна.

Цэвэр хөрөнгө, өмчийн дүн 3,953,877.8 мянган төгрөг болж, 37,990.1 мянган төгрөгөөр буурсан нь өглөгийг 1,477.1 мянган төгрөгөөр барагдуулсан болон тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд орон нутгийн төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 466,298.7 мянган төгрөгийн санхүүжилт төлөвлөн, нийт урсгал зардалд 466,298.7 мянган төгрөг төлөвлөж, хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний зардал төлөвлөөгүйгээр дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн шууд захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 13,406.9 мянган төгрөгөөр бууруулж, сумын ИТХ-ы 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 04 тоот тогтоолоор орон нутгийн төсвөөс санхүүжих урсгал зардлын эх үүсвэрийг 395,684.2 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний санхүүжилтийг 57,207.6 мянган төгрөгөөр, урсгал зардлыг 395,684.2 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний зардлыг 57,207.6 мянган төгрөг, нийт зарлагын дүнг 452,891.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 04 тоот тогтоолоор орон нутгийн төсвийн шилжих үлдэгдлээс санхүүжих хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний санхүүжилтийг 32,971.7 мянган төгрөгөөр нэмж тодотгол хийгдсэн байна.

### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар орон нутгийн төсвөөс 390,684.2 мянган төгрөг, шилжих үлдэгдлээс 90,178.9 мянган төгрөг, нийт 480,863.1 мянган төгрөгийн буюу 98.9 хувийн урсгал санхүүжилт авч, зориулалтын дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 21,240.2 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт урсгал зардлын гүйцэтгэл 459,622.9 мянган төгрөг буюу 94,6 хувьтай зарцуулсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, гамшгийн үеийн бэлэн байдлыг хангах, хөдөлгөөнт эргүүл хяналтын постын тасралтгүй ажиллах бэлтгэлийг хангах зорилгоор иргэд аж ахуйн нэгжээс ирүүлсэн хандиваас сумын засаг даргын 2021 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/119 дүгээр захирамжаар 4,030.0 мянган төгрөг, 2021 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн А/133 дугаар захирамжаар 2,030.0 мянган төгрөг, 2021 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн А/142 дугаар захирамжаар 9,446.3 мянган төгрөг, 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн А/163 дугаар захирамжаар 3,080.0 мянган төгрөг зарцуулахаар шийдвэрлэгдсэн байна.

Сумын засаг даргын 2021 оны 9 дүгээр сарын 15-ны өдрийн Б/166 дугаар захирамжаар хүчилтөрөгчийн аппарат авахад 1,500.0 мянган төгрөг, шатахууны зардалд 1,000.0 мянган төгрөг, бусад тоног төхөөрөмжийн зардалд 1,000.0 мянган төгрөг, сумын онцгой комиссын бэлэн байдлыг хангах зардалд 1,500.0 мянган төгрөг зарцуулсан байна.

Бороогоулд ХХК нь 2021 оны 2 дугаар сарын 05 нд байгуулсан хамтран ажиллах гэрээнийхээ дагуу Төв аймгийн Борнуур сумын ЗДТГ-д хогны машин 27,000.0 мянган төгрөг, бохирын машин 27,000.0 мянган төгрөг, зөөврийн вагончик 7,500.0 мянган төгрөг, ариун цэврийн байгууламж 27,000.0 мянган төгрөг, төмөр хашааны хайс 3,500.0 мянган төгрөг, явган хүний цементэн зам 1,000.0 мянган төгрөг, оношлуур 500 ширхэг

/ нэг бүр нь 14,5 мянган төгрөг / 7,295.0 мянган төгрөг, нэг удаагийн маск 275.0 мянган төгрөг, нийт 101,070.0 мянган төгрөгийн хөрөнгө, бараа материалын хандив өгсөн байна.

Хамтран ажиллах гэрээний 6 дугаар зүйл заасан хамтын ажиллагааны хороо, түүний үйл ажиллагаа ил тод биш бөгөөд 4 дүгээр зүйлийн 4.3-д “ Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон хэрэгжүүлж байгаа үйл ажиллагааны талаар сумын иргэдэд тогтмол буюу улирал бүр мэдээлэл өгч байх” заалтын хэрэгжүүлэлт тодорхойгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр Prius-20 маркийн автомашиныг Ражего маркийн автомашинаар сольсон зөрчлийг аудитын гол асуудлаар тодорхойлсон. Энэхүү автомашиныг цагдаагийн байгууллагын хяналтанд бүртгэлжүүлж, техникийн тодорхойлолтын хуулбарыг хавсарган Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газрын 2022 оны 02 дугаар сарын 17- ны 03/20 дугаар тоотоор Төв аймаг дахь төрийн аудитын газарт ирүүлсэн байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллийг хуулийн хугацаанд нь 65 мэдээлэл байршуулж, 84 мэдээлэл хугацаа хоцроож 71.8 хувьтай хэрэгжүүлсэн байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-д “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх” зарчмуудыг хангаж, холбогдох заалттай нийцүүлэх шаардлагатай байна гэж дүгнэлээ.

### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 1 төлбөрийн актыг барагдуулж, өгөгдсөн 6 зөвлөмжийн хэрэгжилтийг Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны 6 дугаар сарын 16-ны 03/76 тоот албан бичгээр Төрийн аудитын газарт хүргүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Борнуур сумын Засаг даргын Тамгын газрын дараагийн аудитаар анхаарах асуудлыг доорх байдлаар тодорхойлж байна. Үүнд:

- Жолоочийн замын хуудсыг үндэслэн шатахууны зарцуулалтын тооцоог тухай бүр бодож баталгаажуулсан байдал
- Аймгийн ИТХ-ын шийдвэрийн дагуу хувьчлагдсан болон худалдсан хөрөнгийн орлогыг төсөвт төвлөрүүлсэн байдал

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 394,807.1 мянган төгрөгийн 5 алдаа зөрчил илэрснээс, 359,564.1 мянган төгрөгийн 1 алдааг залруулж, 16,457.6 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 3,785.4 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 15,000.0 мянган төгрөгийн материаллаг бус 2 зөрчилд зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Төсвийн гүйцэтгэлийн тайланд санхүүжүүлэх эх үүсвэрийг ИТХ-ын тогтоолоор батлагдсан төлөвлөгөөтэй тулгахад тодотголын 327,591.3 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийг хэлбэлзэлтэй тулгахад татан төвлөрүүлсэн 31,972.8 мянган төгрөгөөр тус тус тохируулаагүй, нийт 359,564.1 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д “үнэн зөв байх”, 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”, Сангийн сайдын 2006 оны 388 тоот тушаалын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар” - ын 8 дугаар заалтыг болон санхүүгийн тайлангийн аудитын “иж бүрэн байх”, “тохиолдсон байх”, “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхгүйгээр 11 дүгээр сард 3,785.4 мянган төгрөгийн мөнгөн урамшууллыг цалингийн зардлаас 20 хүнд олгосон зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2021 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн 190 дугаар тушаалаар батлагдсан “Зардлын эдийн засгийн ангилалыг ашиглах заавар”-ын 1-д 2101 цалин хөлс болон нэмэгдэл урамшил, 210104 “Урамшуулал гэдэгт ...нэг удаагийн шинжтэй шагнал, тэтгэмж урамшууллын зардал хамаарахгүй” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн аудитын “эрх ба үүрэг”, “нийцсэн бөгөөд зохистой байх”, “ангилал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн” бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

### **4.3 Албан шаардлага**

Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлэхгүйгээр 4 нийлүүлэгчээс 16,457.6 мянган төгрөгийн хөрөнгө төсвөөс худалдан авсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолын 1.1-д “үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах” гэсэнтэй нийцэхгүй бөгөөд санхүүгийн тайлангийн аудитын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “Эрх ба үүрэг” гэсэн батламж мэдэгдлүүдийг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх заалт болон МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.8-д “байгуулсан гэрээ, хэлцэл, холбогдох дүрэм журмыг баримтлаагүй” бол албан шаардлага өгнө гэсний дагуу шийдвэрлэв.

### **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Худалдан авалттай холбоотой асуудал**

##### **1.1. Илрүүлэлт:**

Сангийн яамнаас санхүүжигдсэн 15,000.0 мянган төгрөгийн гэрээний үнийн дүнтэй УБ-Дархан чиглэлийн зам "Борнуур" хөшөө нүүлгэн шилжүүлэх ажлын гүйлгээг цахим баримтаар баримтжуулаагүй зөрчил байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан

ажилтан хариуцна.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “НХМаягт ТМ-5 ebarimt -нд үндэслэн бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрдүүлээгүй” гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "иж бүрэн байх", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**1.2 Өгсөн зөвлөмж:**

Бүх төрлийн санхүүгийн гүйлгээг хийж албан ёсны анхан шатны баримтаар бүрэн бүрдүүлж байх.

**2. Нийцлийн аудиттай холбоотой асуудал**

**2.1. Илрүүлэлт**

Шилэн дансны цахим хуудсанд байршуулах 149 мэдээллээс 84 мэдээлэл хугацаа хоцроож, хэрэгжилт 76,4 хувьтай байна. Мөн 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил гүйлгээний гэрээний дүн, гүйцэтгэлийг өсөн нэмэгдсэн дүнгээр байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн аудитын "толилуулга", "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**2.2 Өгсөн зөвлөмж:** Үнэн зөв, бодитой, ойлгомжтой, иж бүрэн мэдээллийг хуулийн хугацаанд нь байршуулж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Борнуур сумын Засаг даргын Тамгын газар	5	394,807.1	1	359,564.1	1	3,785.4	1	16,457.6	2	15,000.0